



МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү баримт бичгийн зорилго нь Монголын цахилгаан холбоо ХК (цаашид Компани гэх)-ийн оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогыг тодорхойлоход оршино.

1.2. Энэхүү баримт бичиг нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн хүрээнд нээлттэй хувьцаат компанийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагад нийцсэн байна.

ХОЁР. ОРОЛЦОГЧ ТАЛУУД, ЗАРЧИМ

2.1. Оролцогч талууд гэж компанийн үйл ажиллагаанд оролцох сонирхолтой болон үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх чадвартай этгээд, түүнчлэн компанийн үйл ажиллагаа нь шууд болон шууд бусаар өөрсдөд нь нөлөөлж буй талуудыг хэлнэ.

2.2. Оролцогч талын бүлгүүд:

2.2.1. Хувьцаа эзэмшигчид

2.2.2. Ажилтнууд

2.2.3. Үйлдвэрчний эвлэл

2.2.4. Хэрэглэгчид

2.2.5. Харилцагчид

2.2.6. Нийлүүлэгчид

2.2.7. Гэрээт компаниуд

2.2.8. Зээлдүүлэгчид

2.2.9. Төрийн байгууллагууд

2.2.10. Төрийн бус байгууллагууд

2.2.11. Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд

2.2.12. Өрсөлдөгчид

2.2.13. Хэвлэл мэдээлэл

2.2.14. Олон нийт ба нийгмийн бүлгүүд

2.3. Компанийн тогтвортой өсөлтийг хангах дунд, болон урт хугацааны үнэ цэнийг бий болгоход оролцогч талуудын хувь нэмрийг хүлээн зөвшөөрч, эрх ашгийг хүндэтгэн, бүхий л талаар харилцан ашигтай хамтран ажиллах зарчмыг баримтална.

2.4. Компани нь оролцогч талуудтай хамтран ажиллахдаа харилцан ашигтай, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, гагцхүү хуулийн хүрээнд шударга ёс, ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллана.



2.5. Оролцогч талуудад эрсдэл, нөлөөллийн шинжилгээ хийж ангилал үүсгэн, хамаарал, ач холбогдлыг тодорхойлохдоо тэдний учруулж болох эрсдэл, нөлөөллийн материаллаг байдлыг харгалзан үзэж, хамаарал, ач холбогдлын дагуу оролцогч талуудын ангилал бүртэй, хамтран ажиллах зарчмыг баримталж ажиллана.

ГУРАВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ

3.1. Компани нь нийгмийн сайн гишүүн байх зорилгынхоо хүрээнд оролцогч талуудтай хамтран ажиллаж, нийгмийг хөгжүүлэх болон хүрээлэн байгаа орчныг хамгаалахад хувь нэмрээ оруулна.

3.2. Оролцогч талуудын бүлэг, ангилал бүр өөр өөр харах өнцөг, хүлээлттэй байдгийг анхаарч үзэн тус бүрд нь тохирсон харилцах, хамтран ажиллах стратеги, арга хэлбэр, зарчимтай байна.

3.3. Компани нь оролцогч талуудтай үр дүнтэй харилцаа холбоо үүсгэхийн тулд олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэн тэдэнд хамаарах санхүүгийн үйл ажиллагааны бүхий л мэдээллийн ил тод байдлыг холбогдох хууль, журмын хүрээнд хангаж ажиллана.

3.4. Оролцогч талуудтай сайн харилцаа, итгэлцэл үүсгэхийн тулд оролцогч талуудын бүлэг, ангилал бүр болон нөхцөл байдал, үргэлжлэх хугацаа, орон нутгийн соёлд тохирсон харилцааны тодорхой стратеги, арга, хэлбэр, зарчмыг хэрэгжүүлэх замаар нягт харилцаж, харилцан ойлголцлыг тууштай бий болгохыг компанийн бүхий л түвшинд зорьж ажиллана.

3.5. Оролцогч талуудын санаа бодол, хүлээлт, хэрэгцээг ойлгохын тулд өөрсдөд нь нөлөөлж буй асуудлуудад оролцохыг дэмжиж, тэдний санал гомдлыг хүлээн авах сувгаар хангаж, ач холбогдол өгч, санал бодлоо солилцон, шаардлагатай тохиолдолд тухайн асуудлыг компанийн эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлнэ.

3.6. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудаст хууль, журмаар хориглоогүй, компанийн бизнесийн болон технологийн нууцад хамаарахаас бусад бүхий л мэдээллийг тухай бүр нийтэлж, бүхий л түвшний талуудтай шууд харилцах боломжтой байдлаар цахим хуудсыг үр дүнтэй ажиллуулна.

ДӨРӨВ. БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

4.1. Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ гэх) нь оролцогч талуудын ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж, тэдгээрийг зохистойгоор тэнцвэржүүлэх шийдвэрийг гаргах, Гүйцэтгэх удирдлагад чиглэл өгөх зэргээр шийдвэрлэнэ.

4.2. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг компанийн хэмжээнд төлөвшүүлэх асуудлыг хамтран зохион байгуулна.

4.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тухайлан тусгасан байна.

4.4. Компани нь оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах энэхүү бодлогыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан компанийн хэмжээнд мөрдөгдөх дүрэм, журам, иргэн хуулийн этгээдтэй байгуулах гэрээнд тухайлан тусгаж өгнө.

4.5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага нь энэхүү бодлогыг хэрэгжүүлэх тодорхой хэмжээний зардлыг бизнес төлөвлөгөөнд тусгаж, чадварлаг, мэдлэгтэй боловсон хүчин болон оролцогч талуудаас санал авах, мэдээлэл бүрдүүлэх чиг үүргийг зохион байгуулалтын бүтцийн аль нэг нэгжид хариуцуулна.

4.6. ТУЗ-ийн аудитын хороо нь оролцогч талуудтай холбоотой үүсэж болох эрсдэлүүдийг тодорхойлон, нөлөөллийг тогтоож, авах арга хэмжээг боловсруулан, хэрэгжилтэд нь хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

ТАВ. ХЯНАЛТ, САЙЖРУУЛАЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

5.1. Энэхүү бодлогын баримт бичгийг ТУЗ-ийн шийдвэрээр өөрчилж, хүчингүй болгоно.

5.2. Энэхүү бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд эрх бүхий албан тушаалтанд чиглэл өгч, бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэх эрхтэй.

ooOoo